



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
7 дугаар сарын 07-ны өдрийн Р-2023-48 дугаар тогтоолын Хавсралт



СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ЭТГЭЭД БОЛОН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ

Боловсруулсан: Илия Аврамов, Эрсдэл хариуцсан захирал

Хувилбар: 1.0

Огноо: 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

журмын 3.3-т тодорхойлсны дагуу Банкны холбогдох этгээдтэй хийсэн активын болон активын бус хэлбэртэй хэлцлийг хэлнэ.

- 1.3.4. “Сонирхлын зөрчилтэй хэлцэл” гэж Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-т тодорхойлсны дагуу Банкны энгийн хувьцааны 20 болон түүнээс дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхол бүхий этгээдтэй хамтран эзэмшиж байгаа этгээд нь хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж буй хэлцлийг хэлнэ.

Хоёрдугаар зүйл. Удирдлага, зохион байгуулалт

- 2.1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү журмыг батална.
- 2.2. Банкны Гүйцэтгэх захирал энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 2.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь журмын хэрэгжилт, сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хийх хэлцэлд хяналт тавина.
- 2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлд сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хийх хэлцэлтэй холбоотой хараат бус баталгаажуулалтыг гаргаж өгнө.
- 2.5. Монголбанкны журам, зохицуулалт болон холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд энэхүү журамд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах ба Төлөөлөн удирдах зөвлөл нь нэмэлт өөрчлөлтийг батална.

Гуравдугаар зүйл. Холбогдох этгээд болон холбогдох этгээдтэй хийх хэлцлийг тодорхойлох

- 3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Банкны холбогдох этгээд болон холбогдох этгээдтэй хийсэн хэлцлийн талаарх мэдээллийн санг Монголбанкнаас баталсан Банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журамд заасан маягтын дагуу бүрдүүлэн хадгална.
- 3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Банкны холбогдох этгээдийн мэдээллийг цаг тухайд нь шинэчлэн хадгалах бөгөөд мэдээллийн сан нь дараах ерөнхий мэдээллийг агуулсан байна. Үүнд:
 - 3.2.1. Холбогдох этгээдийн нэр;
 - 3.2.2. Холбогдох этгээдийн төрөл (Хуулийн этгээд/хувь хүн);
 - 3.2.3. Банктай хамаарал;
 - 3.2.4. Холбогдох этгээдийн тодорхойлолт;
 - 3.2.5. Холбогдох этгээдийн регистрийн дугаар;
 - 3.2.6. Холбогдох этгээдийн үйл ажиллагааны чиглэл;
 - 3.2.7. Холбогдох этгээдийн ажил эрхлэлт;
 - 3.2.8. Холбогдох этгээдийн албан тушаал.
- 3.3. Эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу шаардсан болон бусад шаардлагатай мэдээллийг тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар дамжуулан Төлөөлөн удирдах зөвлөлд мэдээлнэ. Хагас жил тутамд мэдээлэх толилуулгын хуудаст агуулагдах мэдээлэл болон Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах шаардлагатай аливаа өөрчлөлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга жил бүр хянана.

- 3.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь холбогдох этгээдийн мэдээллийг хагас жил тутамд буюу 2 болон 4 дүгээр улиралд шинэчилнэ.
- 3.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь холбогдох этгээдийн мэдээллийг Санхүү хариуцсан захирал, Эрсдэл хариуцсан захирал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны нарийн бичгийн даргад хагас жил тутамд буюу 2 болон 4 дүгээр улиралд тус тус шинэчлэн хүргүүлнэ.
- 3.6. Эрсдэл хариуцсан захирал нь балансын болон балансын гадуурх зээлийн үлдэгдэл, хэлцлийн төрөл, хэлцлийн хэмжээ, хязгаар үзүүлэлтийн биелэлт зэрэг мэдээллийг шинэчлэн хадгална.
- 3.7. Санхүү хариуцсан захирал нь эх үүсвэр, өр төлбөр, үйлчилгээ үзүүлэх гэрээ хэлцэл, хөрөнгө худалдан авалт, борлуулалт, түрээсийн гэрээ, санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцэл, тэдгээрийн төрөл, төлөгдөөгүй үлдэгдэл зэрэг бусад хэлцлийн мэдээллийг шинэчлэн хадгална.

Дөрөвдүгээр зүйл. Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хийх хэлцлийг батлах

- 4.1. Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хийх дараах хэлцлийг Банкны ердийн бизнесийн үйл ажиллагааны хүрээнд батална. Үүнд:
 - 4.1.1. Ердийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой томилолтын зардал, урьдчилгаа төлбөр, нөхөн олговор, захиргааны зардал;
 - 4.1.2. Банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд Банкны бодлого журмаар батлагдсан нөхцөлөөс онцгой бус, давуу байдал үүсгээгүй аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээ;
 - 4.1.3. Ажилтны хөнгөлөлт, хангамжийн хөтөлбөрийн хүрээнд Банкны нийт ажилтнууд, гүйцэтгэх удирдлагад олгох хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнээс бусад хэлцлүүд;
 - 4.1.4. Банкны бодлого, журмаар батлагдсан бусад гуравдагч этгээдэд үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлтэй ижил нөхцөлтэй холбогдох этгээдэд олгосон 100% хадгаламж барьцаалсан зээл.
- 4.2. Банкны гүйцэтгэх удирдлагын дэргэдэх зээлийн санал шийдвэрлэх эрх бүхий этгээд нь сонирхлын зөрчилтэй этгээд эсхүл холбогдох этгээдийн зээлийг шийдвэрлэхдээ тухайн зээлийн нөхцөл нь ердийн бизнесийн үйл ажиллагааны хүрээнд Банкны бодлого журамд заасан бүтээгдэхүүний нөхцөлөөс онцгой, давуу тал үүсгэсэн эсэхээс үл хамааран дараах эрх хэмжээний хүрээнд зээлийг шийдвэрлэнэ. Үүнд:
 - 4.2.1. Орон сууцны зээлээс бусад 300 сая төгрөг хүртэлх зээлийн санал;
 - 4.2.2. 200 сая төгрөг хүртэлх орон сууцны зээлийн санал;
 - 4.2.3. Нийт эрхийн хэмжээ нь 300 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.
- 4.3. Төлөөлөн удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь энэхүү журмын 4.2-т заасан эрхийн хэмжээнээс давсан сонирхлын зөрчилтэй этгээд эсхүл холбогдох этгээдийн зээлийн саналыг шийдвэрлэхээс гадна Банкны гүйцэтгэх удирдлагын дэргэдэх зээлийн санал шийдвэрлэх эрх бүхий этгээдийн энэхүү журмын 4.2-т заасны дагуу шийдвэрлэсэн зээлийг улирал тутамд баталгаажуулна.

- 4.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь холбогдох этгээдийн сангаас хаах зээлийн саналыг шийдвэрлэнэ.
- 4.5. Банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад гуравдагч этгээдтэй хийх хэлцлийн нөхцөл, шаардлагатай ижил төстэй тохиолдолд зээл шийдвэрлэхээс бусад холбогдох этгээдтэй хийх хэлцлийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах шаардлагагүй.
- 4.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд нь өөрийн хамаарал бүхий этгээд болон сонирхлын зөрчилтэй аливаа хэлцлийн шийдвэр гаргалтанд оролцох эрхгүй байна.

Тавдугаар зүйл. Мэдээлэх, тайлагнах

- 5.1. Банк нь холбогдох хууль тогтоомж, журмын дагуу сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хийсэн бүхий л хэлцлийн талаарх мэдээллийг Банкны жилийн тайланд тусган хувьцаа эзэмшигчдэд тайлагнана.
- 5.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хагас жил тутамд Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороогоор баталгаажсан холбогдох этгээдүүдийн мэдээлэл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хянасан Аудитын хорооны тайланг Монголбанкны Банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хянах журамд заасан хугацаанд багтаан Монголбанканд хүргүүлнэ.